ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН
АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

**Уриа: "Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо"**

**Үндсэн мессеж: Хүчээ урвуугаар биш зөвөөр ашиглая, Эрхэм бүхнээ нандигная**

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр.

2022 оны 12 дугаар сарын 12. Багануур дүүрэг

| № | Үйл ажиллагааны чиглэл | Арга хэмжээ | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| **Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэл** | | | | |
| **2.2.1. Зорилт 1.** Дүүргийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, хяналт шинжилгээнд жендэрийн мэдрэмжтэй арга зүй нэвтрүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн ажилтнуудын жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх | | | | |
| **Хүрэх үр дүн:** Дүүргийн төрийн албан хаагч, ААНБ-ын удирдлага, ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, хандлага өөрчлөгдөн бодлого төлөвлөлт, төсөв жендэрийн мэдрэмжтэй болно. | | | | |
| 1. | Төрийн байгууллагын ажиллагсдын Ажил – ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх | **Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо** Албан хаагчдын ажил - ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хөдөлмөрийн ` дотоод | Дэлхийн 180 гаруй улс 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянг зохион байгуулдаг энэ хүрээнд Байгууллагын хамт олонд Монгол улсын Засгийн газрын Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 03/220 дугаартай албан бичиг болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2022 оны 03/5998 дугаартай албан бичиг тус бүрийг байгууллагын хамт олонд танилцуулж энэ сэдвийн хүрээнд мэдээлэл танилцуулга хийл Дэлхий нийтийн энэ аяны үйл ажиллагаанд манай байгууллага нэгдэн төлөвлөгөө гаргаж ажилаллаа. Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо хамгаалъя уриаг байгууллагын албан хаагчдад болон иргэдэд хүргэх нөлөөллийн арга хэмжээг иргэдэд хүргэх чиглэлээр тараах материал 50-ыг бэлтгэн тараалаа. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | журамд тусган, хэрэгжилтийг хангах | - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 218 дугаар тогтоолын дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд оруулсан хүчирхийлэлтэй холбоотой заалтуудын хүрээнд албан хаагчдаас ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой санал асуумжийг авсан. Гэр бүлийн хүчирхийлэл болон ажлын байрны бэлгийн дарамтад орсон, ертсен албан хаагч байхгүй.<br>- Байгууллагын хэмжээнд ямар нэгэн хүчирхийллийн хэлбэр байдаггүй. | |
| **2.2.2. Зорилт 2.** Гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх | | | | |
| **Хүрэх үр дүн.** Иргэдийн дундах жендерийн талаарх хэвшмэл ойлголт өөрчлөгдөж жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдал багасна. | | | | |
| 2. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтын талаар иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах | "Жендэрт суурилсан 16 хоногийн аян" болгон зарласантай холбогдуулан байгууллагын сайт болон цахим хэрэгслээр **"Хүчээ урвуугаар биш зөвөөр ашиглая, Эрхэм бүхнээ нандигная"** Үндсэн мессежийг нийгэмд хүргэх | Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, жендэрт суурилсан аливаа ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтыг өөрчлөх, энэ төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү аяныг тэмдэглэн өнгөрүүлэх хугацаанд байгууллагын www.shilendans.mn сайтад дараах зургуудыг нөлөөллийн арга хэмжээ болгон байршууллаа.<br><br><br><br><br>Энэ жил жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нөлөөллийн арга хэмжээг авах | “Нандин бүхнээ хамгаалъя” уриан дор **“Хүчээ урвуугаар биш зөвөөр ашиглая, Эрхэм бүхнээ нандигная”** мессежийг нийгэмд хүргэхээр нэгдэн ажиллаж байна.Зурагт өгүүлэмж, мессежийг цахим хэлбэрээр хүргэж байна.<br><br><br><br><br><br><br>Мөн “ Намайг алгас” нөлөөллийн аянг Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянтай давхцуулан зохион байгуулж байгаа нь нийгэмд нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлсэн арга хэмжээ боллоо | |
| 3. | Ажил олгогч нь ажилтны гэр бүлийн байдалд судалгааг хийж, ар гэрийг тохиромжтой хэлбэрээр дэмжиж, хорт зуршил бүхий ажилтныг эрүүл амьдралын зөв дадал хэвшилд шилжихэд дэмжсэн орчин бүрдүүлэх | Албан хаагчдын гэр бүлийн байдалд судалгаа хийж тохиромжтой хэлбэрээр дэмжлэг үзүүлэх | - Байгууллагын хэмжээнд архи хэтрүүлэн хэрэглэдэг болон тамхи татдаг, дам тамхидалтанд өртсөн албан хаагч байхгүй.<br>- Байгууллагын зүгээс ажилтны гэр бүлийн байдалд судалгаа хийх, албан хаагч болон ар гэрийг тохиромжтой хэлбэрээр дэмжих, ажил, амьдралын зөв дадал хэвшилд суралцах, энэ тухай мэдлэг, мэдээллийг олж авах мессежийг нөлөөллийн арга хэлбэрээр хүргэж байна.<br>- Мөн энэ аяны хугацаанд Багануур дүүргийн МСҮТөвийн суралцагч өсвөр насны 32 хүүхдүүдэд “Бид ойлгоно-бид хүндэлнэ” сэдвээр яриа хийж аяны ажлын талаар мэдээлэл хийлээ.<br>- Аяны ажилтай холбогдуулан тараах материал, санамж зураг, 50 ширхэгийг иргэд хүүхдүүдэд тарааж нөлөөллийн ажлыг зохион байгууллаа. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2.2.4. Зорилт 4.** Дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэр замаар хүний хөгжлийг дэмжих | | | | |
| **Хүрэх үр дүн.** Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч жендэрийн эрх тэгш байдал хангагдана. | | | | |
| 4. | Ажил олгогчийн зүгээс иргэдийг ажилд авах, албан тушаал дэвшүүлэхэд эрэгтэй хүнийг илүүд үзэх хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүрэгтэй нь холбогдуулан ялгаварлахгүй байх, тухайн байгууллагад цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох замаар хүйсийн тэнцвэрт байдлыг хангах | Ажил олгогчийн зүгээс жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажилд авах | Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангаж үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Хүчирхийллийн хохирогч болохгүй байхын төлөө олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх чиглэлд төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах нь үр дүнтэй байх талаар албан хаагчаас санал гарлаа. | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ПРОГРАММ ХАНГАМЖ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН САН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХДУЛАМ